

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН-МОНГОЛ УЛСЫН ШАДАР  
САЙДЫГ ТОМИЛОХ ТУХАЙ АСУУДЛААР ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН  
ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 09 дүгээр  
сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын  
гишүүн Р.Гончигдорж**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу Цэрэндашийн Оюунбаатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдаар томилуулах саналаа 2015 оны 9 дүгээр сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүллээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2015 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаараа уг асуудлыг хэлэлцэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.6 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдаар томилуулах тухай асуудлаар дараах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Ц.Оюунбаатар нь 1977-1979 онд Дорноговь аймагт хэсгийн прокурор, 1984-1987 онд Завхан аймгийн прокурорын орлогч, 1990-1992 онд Улсын прокурорын газрын ерөнхий хяналтын газрын дарга, 1992-2000 онд Удирдлагын академд ахлах багш, дэд профессор, 2000-2004 онд Улсын Их Хурлын гишүүн, 2004-2008, 2011-2012 онд "Консенсус" төрийн бус байгууллагын захирал, 2008-2010 онд Татварын ерөнхий газрын дарга, 2013-2014 онд Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, 2012 оноос Улсын Их Хурлын гишүүнээр, төрийн албанд 24 жил ажиллаж байгаа бөгөөд Засгийн газраас дэвшүүлж байгаа зорилтыг хэрэгжүүлэх болон танхимын зарчмаар ажиллах чадвар, удирдан зохион байгуулах чадвар, ажил хэрэгч чанар зэргийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдаар томилуулахаар нэр дэвшүүлжээ.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд, С.Дэмбэрэл, Л.Цог, Н.Энхболд нар Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдад нэр дэвшигчийг дэмжиж байгаагаа илэрхийлж төрийн албаны залгамж чанарыг үргэлжлүүлэн, өндөр хариуцлагатай ажиллах талаар үг хэлэв. Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл мэргэжлийн хяналт, стандартын тухай хууль тогтоомжид шинэчлэл хийх; оюуны өмчийн хамгаалалт, түүнийг олон нийтэд сурталчлах чиглэлээр сайн ажиллах; Онцгой байдлын байгууллагын техник, технологийг шинэчлэх талаар анхаарах гэсэн саналыг гаргасан болно.


Ц.Оюунбаатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдаар томилуулах тухай саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжлээ.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдыг томилох тухай асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



А.БАКЕЙ